



# Хөрөнгө оруулалт 2019



Улаанбаатар  
2020



Хянан, тохиолдуулсан:

Д. Мөнхзул

ЧДСХ-ийн дарга

Танилцуулгыг нэгтгэн, боловсруулсан:

Ч.Уртнассан

ЧДСХ-ийн мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Монгол Улс, Улаанбаатар хот

Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж,

Чингэлтэй дүүргийн Засаг захиргааны III-р байр.

Утас : 70130767, 70110767, 11-310767

Цахим хуудас : <http://www.chingeltei.gov.mn>

<http://www.ubstat.mn>

И-мэйл: chingeltei@nso.mn

## ГАРЧИГ

1. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.....	4
2. ДҮГНЭЛТ.....	11

## ЗУРАГ

Зураг 1. Чингэлтэй дүүргийн хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр, 2013-2019 он.....	4
Зураг 2. Нийт хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, хувиар, 2013-2019 он.....	5
Зураг 3. Нийт хөрөнгө оруулалт, салбараар, 2013-2019 он.....	5
Зураг 4. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт дүнд эзлэх хувь сая.төг 2013-2019 он.....	6
Зураг 5. Ашиглалтад орсон авто зам, метрээр, 2013-2019 он.....	6
Зураг 6 . Нийт хөрөнгө оруулалтад хот тохижилтын хөрөнгө оруулалтын эзлэх хувь, 2013-2019 он.....	7
Зураг 7. Хот тохижилтын чиглэлийн хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр 2013-2019 он.....	8
Зураг 8. Дүүрэгт хийгдсэн гэрэлтүүлгийн тоо, мөнгөн дүнээр, сая төгрөгөөр, 2013-2019 он.....	8
Зураг 9. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр, 2013-2019 он.....	9
Зураг 10. Төсвийн хөрөнгө оруулалт, салбараар, сая төгрөг, 2013-2019 он.....	9
Зураг 12. Төсвийн хөрөнгө оруулалтын хувь, салбараар, 2019 он.....	11

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Чингэлтэй дүүргийн хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр, 2013-2019 он.....	5
Хүснэгт 2. Дэд бүтцийн салбарт хийгдсэн зам, төрлөөр, 2013-2019 он.....	7

## ТЭМДЭГЛЭЛ

М <sup>2</sup>	метр квадрат
М <sup>3</sup>	метр куб


## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Дүүрэгт оруулсан нийт хөрөнгө оруулалтыг 2013-2019 оны 6 жилийн хугацаанд авч үзлээ. 2013 оноос 2015 онд хөрөнгө оруулалт өссөн бол 2016 оноос 2017 он хүртэл буурч, 2018 оноос өсөх хандлагатай байна. 2019 онд өмнөх онуудаас хамгийн их хөрөнгө оруулалтыг хийсэн байна. /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Чингэлтэй дүүргийн хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр, 2013-2019 он


	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт хөрөнгө оруулалт	23 618.4	37 124.4	44 462.7	34 993.6	31 171.1	56 029.6	57 029.6

Зураг 1. Чингэлтэй дүүргийн хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр, 2013-2019 он




Нийт хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр авч үзлээ. 2013-2019 оны нийт хөрөнгө оруулалтын дийлэнхийг буюу 12.1-74.5 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалт эзэлдэг бол үүний дараа нийслэлийн хөрөнгө оруулалт эзэлсэн байна. 2016, 2017 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтын 12.1-20.2 хувийг эзлэж байсан ба дүүргийн болон нийслэлийн хөрөнгө оруулалт өндөр байсан байна. 2019 оны хөрөнгө оруулалтад төсөл хөтөлбөрийн эзлэх хувь бусад онуудаас их буюу 13.4 хувийг эзлэж байгааг харж болохоор байна /Зураг 2/.

Зураг 2. Нийт хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, хувиар, 2013-2019 он



Зураг 3. Нийт хөрөнгө оруулалт, салбараар, 2013-2019 он



Хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзлээ. Боловсролын салбарыг авч үзвэл 2013 онд хөрөнгө оруулалтыг 1.8 тэрбум төгрөг буюу 7.8 хувь, 2014 онд 14.4 тэрбум төгрөг буюу 38.8 хувийг, 2015 онд 24.4 тэрбум буюу 54.8 хувь, 2016 онд 10.0 тэрбум буюу 28.6 хувь, 2017 онд 13.6 тэрбум буюу 43.6 хувь, 2018 онд 16.7 тэрбум төгрөг буюу 29.3, 2019 онд 32.3 тэрбум төгрөг

буюу 41.4 хувийг тус тус эзэлж байна. Зураг 3-ыг үзэхэд 2019 онд боловсролын салбарт хамгийн их хөрөнгө оруулалт хийгдсэн харагдаж байна.

### ДЭД БҮТЭЦИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Нийт хөрөнгө оруулалтад дэд бүтцийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын эзлэх хувийг тооцлов. Төсвийн хөрөнгө оруулалт 2013 онд нийт хөрөнгө оруулалтын 79.4 хувийг, 2017 онд 31.7 хувийн хөрөнгө оруулалт хийгдэж байсан. /Зураг 4/.

Зураг 4. Нийт хөрөнгө оруулалталт, сая төгрөгөөр, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын дүнд эзлэх хувь, 2013-2019 он




Дэд бүтцийн салбарын 2013 оноос хойшхи хөрөнгө оруулалтыг мөнгөн дүнээр нь авч үзвэл 2018 онд хамгийн өндөр буюу 21 751.9 тэрбум төгрөг , 2017 онд хамгийн бага буюу 9 893.5 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгө оруулалтын 31.7 хувийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Харин 2019 онд нийт хөрөнгө оруулалтын 29.2 хувийн хөрөнгө оруулалт хийгджээ.

Хүснэгт 2. Дэд бүтцийн салбарт хийгдсэн зам, төрлөөр, 2013-2019 он

	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Авто зам у/м	29820	32604	4123	137800	46980	18686	5103.3
Явган зам м2	11000	7563	34664	18334	20796	12362	22
Бетон зам у/м		165	7701	5146	1619.8	2755.4	0
Байгалийн чулуу у/м	231	342	4318	4448.4	5953.5	1738	610
Эко хавтан м2		963	2160	6689.8	2930	3293	1000

Дэд бүтцийн салбарт хийгдсэн авто болон явган хүний замыг төрлөөр нь авч үзлээ. 2016 онд хамгийн их 137.8 км авто зам ашиглалтад орж байсан бол 2015 онд хамгийн бага 4.1 км зам ашиглалтад орсон байна. Харин 2015 онд 34664 м2 явган хүний зам ашиглалтад орсон байна. Эндээс үзэхэд дэд бүтцийн чиглэлээр хөрөнгө оруулалтын ажил багагүй хийгдэж байгааг харж болохоор байна.

Зураг 5. Ашиглалтад орсон авто зам, метрээр, 2013-2019 он.



**ХОТ ТОХИЖИЛТ, ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙГ САЙЖРУУЛАХ, ЧИГЛЭЛЭЭР:**


Хот тохижилт, хот нийтийн аж ахуйг сайжруулах чиглэлээр хийгдсэн хөрөнгө оруулалтыг 2013 оноос 2019 оны байдлаар харьцуулав. Нийт хөрөнгө оруулалтын 2.3-15.9 хувийг хот тохижилтын хөрөнгө оруулалт эзэлж байгааг харж болохоор байна. /Зураг 6/.

Зураг 6. Нийт хөрөнгө оруулалтад хот тохижилтын хөрөнгө оруулалтын эзлэх хувь, 2013-2019 он




Хот тохижилтын чиглэлээр хийгдсэн хөрөнгө оруулалтаас хамгийн их нь 2013 онд нийт хөрөнгө оруулалтын 15.9 хувь буюу 3 735.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Харин 2019 онд нийт хөрөнгө оруулалтын 2.3 хувь буюу 1 832.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь сүүлийн 7 жилийн хамгийн бага хөрөнгө оруулалтыг хийжээ. /Зураг 7/.

Зураг 7. Хот тохижилтын чиглэлийн хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр 2013-2019 он



Зураг 8. Дүүрэгт хийгдсэн гэрэлтүүлгийн тоо, мөнгөн дүнээр, сая төгрөгөөр, 2013-2019 он




2016 онд 527.7 сая.төгрөгийн буюу хамгийн бага хөрөнгө оруулалт хийгдсэн ба 2013 онд 1632.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 2019 онд 677.6 сая.төгрөг буюу өмнөх оноос 436.4 сая төгрөг буюу 40.1 хувиар буурсан байна. / Зураг 8/

#### ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ:

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн нэгдсэн эмнэлэг 1, өрхийн эрүүл мэндийн 16 төв үйл ажиллагаа явуулж байна. Үүнд нийт 565 эмч, мэргэжилтнүүд ажиллаж байна.



Зураг 9. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр, 2013-2019 он.




Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт 2019 онд бусад салбартай харьцуулахад бага хувийг эзэлж байна. 2013 онд 587.3 сая.төгрөг буюу хамгийн бага, 2019 онд нийт хөрөнгө оруулалтын 7 400.0 сая төгрөг буюу 9.5 хувийг эрүүл мэндийн салбарт төлөвлөсөн байна. /Зураг 9/

### БОЛОВСРОЛЫН САЛБАРТ:

Боловсролын салбарын хөрөнгө оруулалт бусад салбартай харьцуулахад өндөр байгаа бөгөөд 2019 онд 32315.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн ба нийт хөрөнгө оруулалтын 41.4 хувийн хөрөнгө оруулалт хийсэн байна. 2013 онд хамгийн бага буюу 1 821.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. /Зураг 10/.

Зураг 10. Төсвийн хөрөнгө оруулалт, салбараар, сая төгрөг, 2013-2019 он



2014-2017 онуудад 1200 хүүхдийн 8, 2018 онд 715 хүүхдийн 4, 2019 онд 1045 хүүхдийн 5 цэцэрлэг ашиглалтанд орсон байна.

2014-2017 онуудад 360 суудалтай 3, 2018 онд 520 суудалтай 1, 2019 онд 320 суудалтай 1 сургууль тус тус ашиглалтанд оржээ.

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ДҮҮРЭГТ 2014-2019 ОН

## ЦЭЦЭРЛЭГ

2014-2017 онуудад 1200 хүүхдийн 8,  
2018 онд 715 хүүхдийн 4,  
2019 онд 1045 хүүхдийн 5



## СУРГУУЛЬ

2014-2017 онуудад 360 суудалтай 3,  
2018 онд 520 суудалтай 1,  
2019 онд 320 суудалтай 1



## ЭМНЭЛЭГ

2014-2017 онуудад 410 ортой 2 эмнэлэг


## СПОРТЫН ЦОГЦОЛБОР

2014 онд 3200 суудалтай заал,  
2018 он 1390 м2 цогцолбор  
2019 онд 3500 м2 заал,  
спортын цогцолбор



Төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн нутаг дэвсгэрт гүйцэтгэгдэж, ашиглалтад орсон сургууль цэцэрлэг болон спорт заалыг дээрх зургаар үзүүлээ. 2014 оноос 2019 он хүртэл 2960 хүүхдийн 17 цэцэрлэг, 360 суудалтай 3 сургууль, 320 суудалтай 1 сургууль 2018 онд ЭМШУИС-ын 520 суудалтай 1 сургууль, 2014-2017 онд 410 ортой 2 эмнэлэг тус тус ашиглалтад орсон байна.

Зураг 11. Төсвийн хөрөнгө оруулалтын хувь, салбараар, 2019 он.



2019 онд нийт хөрөнгө оруулалтын 32.2 хувийг дэд бүтэц, 29.3 хувийг боловсролын салбар, 20.4 хувийг нийгмийн салбарт, 10.3 хувийг эрүүл мэндийн салбар, 5.9 хувийг хот тохижилт, хот нийтийн аж ахуйг сайжруулах, 1.9 хувийг төрийн захиргааны чиглэлээр хийгдэх ажилд тус тус төсөвлөсөн байна.